

Хавдрын шинжилгээ гэж юу вэ?

Хавдрын шинжилгээнд хамрагдах нь та эрүүл мэнддээ анхаарч буй нэн чухал алхам юм.



Хавдрын шинжилгээ нь хавдрын эрт үеийн шинж тэмдэг, эсвэл хавдрыг үүсгэдэг урьтал байдлыг илрүүлэх зорилго бүхий энгийн шинжилгээнүүд юм. Хавдрын шинжилгээнүүд хавдар танд харагдаж, биед мэдрэгдэхээс өмнө хавдрыг илрүүлэх боломжтой. Хавдрыг эрт илрүүлснээр амжилттай эмчлэхэд дөхөм болдог.

Австрали улсад хавдрыг эрт илрүүлэх зорилготой үндэсний хэмжээний гурван хөтөлбөр байдаг. Эдгээр нь хөхний, умайн хүзүүний болон бүдүүн гэдэсний хавдрыг илрүүлэх хөтөлбөрүүд юм.



Хөхний хавдрын шинжилгээ



Хөхний хавдар бол эмэгтэйчүүдэд хамгийн түгээмэл тохиолддог хавдар юм.

- 50-74 насны эмэгтэйчүүд хоёр жил тутамд маммограм (хөхний рентген ч гэж бас нэрлэдэг) хийлгэж байх хэрэгтэй.
- Маммограм шинжилгээ нь хөхний хавдрыг нүдэнд харагдаж, биед мэдрэгдэхээс ч өмнө илрүүлэх боломжтой хамгийн шалгарсан арга юм.
- 50-74 насны бүх эмэгтэйчүүд үзлэгт хамрагдах нь маш чухал юм. Учир нь хөхний хавдраар оношлогдсон ихэнх эмэгтэйчүүдэд ийм өвчний удамшлын түүх байдаггүй.
- BreastScreen NSW-ээс хэрэгжүүлдэг маммограм шинжилгээ нь **үнэ төлбөргүй** бөгөөд уг шинжилгээнд хамрагдахын тулд та өрхийн эмчээсээ бичиг авах шаардлага байхгүй юм.



Юу хийх хэрэгтэй вэ:

- **13 20 50** дугаараар залгах буюу book.breastscreen.nsw.gov.au веб хуудсаар орж цаг аваарай.
- Орчуулагчийн тусламж хэрэгтэй бол **13 14 50** дугаараар холбогдоорой.
- Өөр бусад хэл дээр мэдээлэл авахыг хүсвэл breastscreen.nsw.gov.au веб хуудсаар зочилно уу.



Бүдүүн гэдэсний хавдрын шинжилгээ



Эрт илрүүлж чадвал бүдүүн гэдэсний хавдрын 10 тохиолдол тутмын 9 нь эмчлэгдэх боломжтой.

- 50-74 насны Медикер карттай эсвэл Department of Veterans Affairs - ийн карттай эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёр жил тутамд нэг удаа **үнэгүй** шинжилгээний багцыг шуудандаа хүлээн авна.
- Бүдүүн гэдэсний хавдрын шинжилгээ нь бүдүүн гэдэсний хавдрыг илрүүлэх хамгийн сайн арга учраас таны амь насыг ч аварч болно.
- Бүдүүн гэдэсний хавдрын шинжилгээ нь та гэртээ хийхэд тохиромжтой хурдан бөгөөд энгийн шинжилгээ юм.



Юу хийх хэрэгтэй вэ:

- Шуудангаар ирсэн гэдэсний хавдрын шинжилгээний багцыг ашиглан та шинжилгээнд хамрагдаарай.
- dothetest.com.au веб хуудсаар зочлон танд дараагийн багцыг хэзээ шуудангаар илгээхийг шалгааарай.
- **1800 627 701** дугаараар холбогдон асууж тодруулах зүйл байвал асуугаарай.
- Орчуулагчийн тусламж хэрэгтэй бол **13 14 50** дугаараар холбогдоорой.
- Өөр бусад хэл дээр мэдээлэл авахыг хүсвэл health.gov.au/resources/translated веб хуудсаар зочилно уу.



Умайн хүзүүний шинжилгээ



Умайн хүзүүний шинжилгээнд хамрагдсанаар та умайн хүзүүний хавдраас өөрийгөө урьдчилан сэргийлж чадна.

- 25-74 насны эмэгтэйчүүд таван жил тутамд нэг удаа умайн хүзүүний шинжилгээ өгч байх хэрэгтэй.
- Умайн хүзүүний шинжилгээнд хамрагдахын тулд өөрийн өрхийн эмч эсвэл сувилагчдаа цаг авч үзүүлээрэй.
- Зарим эмч энэ үйлчилгээг **үнэ төлбөргүй** үзүүлдэг. Та шинжилгээнд хамрагдахаар цаг авахдаа энэ талаар асууж тодруулаарай.
- Умайн хүзүүний шинжилгээнд хамрагдсанаар умайн хүзүүний хавдраас сэргийлэх боломжтой. Учир нь энэхүү шинжилгээгээр уг хавдрыг үүсгэгч халдварт human papillomavirus (HPV) танд байгаа эсэхийг тогтоодог юм.



Юу хийх хэрэгтэй вэ:

- Умайн хүзүүний хавдрын шинжилгээнд хамрагдах цаг болсон эсэхээ **1800 627 701** дугаарт холбогдон шалгана уу.
- Та өөрийн өрхийн эмч буюу сувилагчдаа үзүүлэхээр цаг аваарай. Энэхүү шинжилгээнд хамрагдахдаа та хэрэв хүсвэл эмэгтэй эмч сувилагчаар хийлгүүлэхийг хүсч болно.
- Орчуулагчийн тусламж хэрэгтэй бол **13 14 50** дугаараар холбогдоорой.
- Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл cancer.nsw.gov.au/cervical эсвэл cancerscreening.gov.au/cervical веб хуудсаар зочилно уу.